



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 9 сарын 12 өдөр

Дугаар 310

Улаанбаатар хот

Г “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги,  
төлөвлөгөө (2018-2021 он)” батлах тухай

Улсын Их Хурлын 2006 оны 45 тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.1.4 дэх заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө (2018-2021он)”-г хавсралтаар баталсугай.

2. Стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, биелэлтийг хууль, тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагуудад тайлагнахыг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн  
310 дугаар тогтоолын хавсралт



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨ”  
(2018-2021 он)

УЛААНБААТАР ХОТ  
2018 он

<b>АГУУЛГА</b>	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	3
НЭГ. ОРШИЛ.....	4
ХОЁР. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА.....	5
2.1 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА.....	5
2.2 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН ҮНДСЭН ЗАРЧИМ.....	6
2.3 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН ҮНДСЭН ЗАГВАР.....	7
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ .....	8
3.1 БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ.....	8
3.2 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	9
3.3 САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ .....	11
3.4 ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС.....	11
3.5 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГ ХАНДЛАГА .....	12
ДӨРӨВ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	13
4.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	13
4.2 ХҮНИЙ НӨӨЦ.....	15
4.3 ХАНГАМЖ.....	18
4.3 ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ .....	19
4.4 СВОТ ШИНЖИЛГЭЭ.....	22
ТАВ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨ (2018-2021).....	24
ЗУРГАА. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	34
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....	34
ХАВСРАЛТ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭМЖҮҮР ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	0

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
ЗҮХ	Зохицуулалт үйлчилгээний хөлс
МУ	Монгол Улс
МХБ	Монголын хөрөнгийн бирж
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУ	Олон улс
ОУВС	Олон улсын валютын сан
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
УИХ	Улсын Их Хурал
ҮЦК	Үнэт цаасны компани
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮ	Хяналт, шалгалт, үнэлгээ

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Стратеги төлөвлөгөөний арга зүйн дараалал.....	7
Зураг 2. Хөрөнгийн зах зээлийн ДНБ-д эзлэх хувь /тэрбум төгрөг/.....	8
Зураг 3. Гадаад худалдааны 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, 2018-2020 оны төсөөлөл /тэрбум ам.доллар/.....	10
Зураг 4. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн талаарх олон улсын байгууллагуудын төсөөлөл 12	
Зураг 5. Хорооны одоогийн нөхцөл байдлын талаар 1-5 хүртэл онооны үнэлгээ (1 - маш муу, 5 - маш сайн).....	17
Зураг 6. Чиг үүрэгтэй холбоотой ажлын давхардал 1-5 хүртэл онооны үнэлгээ .....	17
Зураг 7. Хорооны албан хаагчдын сүүлийн нэг жилийн хугацаанд хорооны үйл ажиллагаанд холбогдолтой Монгол Улс болон гадаадын улс оронд сургалтад хамрагдсан байдал .....	18
Зураг 8. Хорооны албан хаагчдын ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд тулгардаг бэрхшээл .....	19
Зураг 9. Хэрэглэж буй техник, програм хангамжаас сайжруулах шаардлагатай .....	19
Зураг 10. Хорооны батлагдсан төсөв болон ОУ-ын төсөл хөтөлбөр, тусламж .....	20
Зураг 11. 2017 оны төсөвт зардлын хуваарилалт.....	20
Зураг 12. Хорооны үндсэн хөрөнгийн хангамж.....	21
Зураг 13. Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийн ангилал.....	21

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Логик загварын ерөнхий бүтэц.....	7
Хүснэгт 2. ДНБ-ий хэмжээ, өсөлт.....	10
Хүснэгт 3. Гадаад орон болон олон улсын хамтын ажиллагаатай байгууллагууд.....	15
Хүснэгт 4. СЗХ-ны албан хаагчдын бүтэц .....	16
Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн хураангуй тайлан .....	18

## НЭГ. ОРШИЛ

Монгол Улсын Их Хурлаас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг 2006 оны 01 дүгээр сард баталснаар Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэйгээр байгуулагдсан билээ.

Өнгөрсөн хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэйгээр хэрэгжүүлэх зорилгоор “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөө 2008-2010” болон “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги 2012-2016”-г тус тус батлан салбарын хууль эрх зүй, зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, санхүүгийн зах зээлд оролцогчдыг чадавхжуулах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад анхаарч ажилласан.

“Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги 2012-2016”-д үндсэн 4 зорилгын хүрээнд үнэт цаасны зах зээл, даатгал, бичил санхүүгийн салбар болон туслах үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх зорилтыг тодорхойлон хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- 1) Монгол Улсын санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах;
- 2) Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох;
- 3) Харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах;
- 4) Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх.

Эдгээр зорилтуудын хүрээнд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг шинэчлэн боловсруулан Монгол Улсын Их Хурлаар 2013 онд батлуулсан. Дээрх хуулиудад нийцүүлэн холбогдох дүрэм, журмыг шинэчлэн баталж, шинээр үүсч бий болох кастодиан банк, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг бодлогоор дэмжин үнэт цаасны төлбөр тооцооны шинэ горимыг нэвтрүүлэхээр зохицуулалтын орчинг бүрдүүлжээ.

Даатгалын салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлж, зайны хяналтыг үр дүнтэй болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчид болон зах зээлд оролцогчдыг мэргэшүүлэх сургалтуудад хамруулж, хяналт шалгалтын гарын авлагыг боловсруулав. Мөн албан журмын жолоочийн хариуцлагын даатгалын мэдээллийн нэгдсэн санг үүсгэн даатгагч нарт энэ төрлийн даатгалын эрсдэлийг нарийвчлан үнэлэх боломжийг олгоод байна. Даатгалын нөөц сангийн хөрөнгийг зөвхөн арилжааны банкинд байршуулах зохицуулалтыг өөрчлөн хөрөнгийн зах зээлийн 1 дүгээр ангиллын хувьцаа болон хамтын хөрөнгө оруулалтын санд тодорхой хувиар байршуулах боломжийг хуулиар олголоо.

Бичил санхүүгийн салбарт Азийн хөгжлийн банкны тусламжтайгаар хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааны бодлогын баримт бичгийг боловсруулж, нягтлан бодох бүртгэлийн программыг нэвтрүүлсэн бол банк бус санхүүгийн байгууллагууд удирдлагын мэдээллийн системийг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн байна.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны архивыг цахим системд шилжүүлэх зорилгоор албан хэрэг хөтлөлтийн “Бүтээмж-2016” программыг нэвтрүүлж, зайны хяналтыг хэрэгжүүлэх Фин-А санхүүгийн шинжилгээний программаар зохицуулалттай этгээдүүдийн санхүүгийн тайланг хүлээн авч, 2006 оноос хойших зохицуулалттай этгээдүүдийн санхүүгийн тайланг нөхөж байршуулсан байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь үйл ажиллагааны 2 дахь стратегийг амжилттай хэрэгжүүлж, хууль эрх зүйн орчныг шинэчлэн, олон нийтийн санхүүгийн боловсрол, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрхийн хамгааллыг сайжруулсан.

Цаашид Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг улам идэвхжүүлснээр зохицуулалтын салбаруудын хөгжлийг бодлогоор дэмжин олон тулгуурт санхүүгийн зах зээлийн тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө 2018-2021”-ийг боловсрууллаа.

Уг дунд хугацааны стратегийг боловсруулахад Санхүүгийн зохицуулах хорооны өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэн гадаад болон дотоод орчны шинжилгээ хийж, урьдач нөхцөлөө тогтоон хэр хэмжээний нөөц ашиглаж, юуг бүтээснээр үр дүнд хүрэх логик загварыг ашиглан энэхүү стратегийн зорилго, зорилтууд, тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлов.

## **ХОЁР. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА**

### **2.1 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА**

Өнгөрсөн хугацаанд “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөө 2008-2010” болон “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги 2012-2016”-г тус тус батлан хэрэгжүүлсэн нь салбарын хууль эрх зүй, зохицуулалтын орчинг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэснийг онцлох нь зүйтэй.

Ялангуяа “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги 2012-2016”-д салбар тус бүрийн хөгжлийг бие даасан байдлаар нь харж, бодлогын шийдлийг дэвшүүлсэн анхны тохиолдол байв.

Уг баримт бичгүүд нь банк, санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх чиглэлд тодорхой үр дүнгээ өгчээ.

Тухайлбал, байгалийн баялаг, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн нөөцдөө тулгуурласан боловсруулах үйлдвэрлэл болон аялал жуулчлал, эрүүл мэнд, боловсрол зэрэг бусад тэргүүлэх салбаруудаа хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг дотоодын хөрөнгийн зах зээлээсээ босгох боломж, нөхцөл бүрдэж эхлээд байгаа нь сүүлийн 2 жилд амжилттай хийгдсэн IPO-ийн туршлагаудаас харагдаж байна.

Гэсэн хэдий ч, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдааг хангах, банкнаас бусад санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны цар хүрээг эрчимтэй өргөтгөх, хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын хөгжлийг олон улсын жишигт хүргэх зорилтуудын хэрэгжилт хангалтгүй байгаа нь санхүүгийн салбарын өнөөгийн байдлын үнэлгээнээс харагдаж байна.

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн өнөөгийн бүтэц нь банкны салбарт төвлөрсөн, богино хугацаат, өндөр өртөгтэй санхүүжилтээс хамааралтай хэвээр байгаа тул эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд хангах, хуримтлал, хуваарилалтын оновчтой тогтолцоог бүрдүүлж санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

Дүгнэж хэлбэл, Монгол Улсад дотоодын хуримтлалыг үр ашигтайгаар дайчлан гадаадын хөрөнгө оруулалт орох сувгийг нэмэгдүүлж эдгээрийг нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтад байршуулах чадавхтай, зохистой бүтэц бүхий санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ үүсээд байна.

Нөгөөтэйгүүр олон улсын санхүү, бизнесийн харилцаа, хөрөнгийн урсгал нэг улс дотор хязгаарлагдах боломжгүй үндэстэн дамнасан хэлбэрт шилжсэний дээр тухайн улсын санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа нь олон салбар, зах зээлийг зэрэг хамрах болж санхүүгийн бүх ажил үйлчилгээг нэг байгууллагын, нэг салбарын хэмжээнд хэмжиж дүгнэх, зохицуулах боломжгүй буюу зах зээлийг бүх түвшинд нь харилцан уялдаатай зохицуулж хөгжүүлэх, оролцогч бүх талыг хамарсан бодлого үгүйлэгдэж байна.

Иймд санхүүгийн зах зээлийн эдийн засаг дахь гүнзгийрэлт, үйлчилгээний хүртээмж, үр ашиг, тогтвортой байдлыг ханган өрсөлдөх чадварыг бэхжүүлэн олон улсын интеграцчилалд нэгдэх зорилгыг агуулж, хүртээмжтэй, технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж төрөлжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог хангах, зах зээлд оролцогчдын эрсдэл даах чадварыг сайжруулж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн санхүүгийн зах зээлийг дунд хугацаанд хөгжүүлэх шинэчлэл, хөгжлийн стратегийн төслийг боловсруулаа.

Уг стратегийн тэргүүлэх чиглэл нь ногоон эдийн засгийг дэмжсэн байгаль орчин, нийгэмд ээлтэй хариуцлагатай, тогтвортой санхүүжилт, шинэ технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжил, тэдгээрийн зохицуулалтын орчинг дэмжих, санхүүгийн хэрэглэгчдийн хамгааллын тогтолцоог шинэ шатанд хөгжүүлснээр иргэдийн санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг дээшлүүлэх явдал юм.

## **ЗАЛГАМЖ ХАЛАА**

Аливаа стратеги төлөвлөгөө нь залгамж чанар буюу өнгөрсөн хугацаанд хийгдэж байсан ажлуудаа үргэлжлүүлэн тусгаж уялдах зарчмаар ажиллах нэн шаардлагатай билээ. Иймд “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги 2012-2016”-д хийгдэж байсан болон цаашид хэрэгжүүлэхээр зорьсон зорилго, зорилт, үйл ажиллагааг судлан авч “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги, төлөвлөгөө 2018-2021”-д үргэлжлүүлэн сайжруулахаар тусгаж өглөө.

2012-2016 оны хооронд хэрэгжсэн стратеги төлөвлөгөөний үйл ажиллагаануудын дийлэнх хувийг шинэчилсэн стратеги төлөвлөгөөнд тусган сайжруулж, зорилго санааг алдагдуулахгүй үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болсон ба тодорхой хувь нь тухайн хугацаанд хэрэгжиж дууссан, үргэлжлүүлэх шаардлагагүй ажлууд байлаа. Мөн уг стратеги нь санхүүгийн зах зээлийн хурдацтай өөрчлөлтөөс хамаарч буй ногоон эдийн засаг, гарааны бизнес, тогтвортой санхүүжилт зэрэг шинэлэг үйл ажиллагааг тусгаж өгснөөр онцлог юм.

Өмнөх стратеги төлөвлөгөө нь үндсэн 4 салбарын дагуу зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг тус бүрийн онцлогоор уялдуулж ялгаатай загвар, аргачлалаар тодорхойлж төлөвлөсөн бол энэ удаагийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө зарчмын ялгаатай болно.

## **2.2 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН ҮНДСЭН ЗАРЧИМ**

Санхүүгийн зохицуулах хорооны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмуудыг баримталсан болно. Үүнд:

- ✓ Стратеги төлөвлөгөө боловсруулах онол, арга зүйг баримтлах;
- ✓ Судалгаа, шинжилгээнд үндэслэх;
- ✓ Батлагдсан эрх зүйн баримт бичиг, бодлого, хөтөлбөртэй нийцүүлэх;

- ✓ Байгууллагын хүний нөөц, чадавхын давуу талд тулгуурлахын зэрэгцээ сул тал, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх асуудлыг төлөвлөгөөнд тусгагдсан аль ч асуудлын хувьд харгалзан үзэх;
- ✓ Ажиллагсдын бүтээмжийг нэмэгдүүлэх замаар үйл ажиллагааны хүртээмж, чанарыг дээшлүүлэх;
- ✓ Гадаад, дотоод хүчин зүйлсийн боломжийг зөв үнэлж, ашиглах.

Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг Хорооны ажлын албаны даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, бусад ажилтан, албан хаагчдыг оролцуулж, өнөөгийн төлөв байдал, үндэслэл, орчны шинжилгээ, алсын хараа, эрхэм зорилго, зорилго, стратегийн зорилтууд, стратегийн дэд зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн, хяналт, үнэлгээ гэсэн арга зүйн дарааллын дагуу гүйцэтгэлээ.

Зураг 1. Стратеги төлөвлөгөөний арга зүйн дараалал



### 2.3 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН ҮНДСЭН ЗАГВАР

Логик загвар: Логик загвар нь ихэвчлэн хүлээж байсан үр дүнгийн өөрчлөлт, хийхээр төлөвлөж байгаа үйлдэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд байгаа нөөц хоорондын уялдаа, үр дагаврын холбоог схемчилсэн загварчлалаар харуулдаг. Логик загварчлал нь нарийвчилсан төсөөлөл зураглах арга замаар энгийн бөгөөд нүдэнд ил харагдах байдлаар илэрхийлж, мөн анхаарвал зохих үйл ажиллагаа, үр бүтээл, гарц болоод харилцааг тодорхой болгож өгдөгөөрөө бусад загваруудаас онцлогтой юм.

Хүснэгт 1. Логик загварын ерөнхий бүтэц

ҮНДСЭН ХЭСЭГ /ДУНД ХУГАЦАА/	Алсын хараа
	Эрхэм зорилго
ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТ	Стратегийн зорилт ба дэд зорилт
НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ /БОГИНО ХУГАЦАА/	Үйл ажиллагааны төлөвлөгөө
ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛЭМЖЭЭР ТОДОРХОЙЛОХ ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	Хүн, хугацаа, санхүү, техник хангамж
	Хариуцах газар, хэлтэс, алба, нэгж
	Хүрэх үр дүн
	Хэмжих нэгж

Стратеги төлөвлөгөө боловсруулах ажилд Санхүүгийн зохицуулах хорооны газар, хэлтсийн дарга нар, Ажлын албаны даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг оролцуулахаас гадна бусад ажилтан, албан хаагчдыг саналаа тусгах боломжоор хангасан болно.

Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг нь судалгааны тайлан, хууль, эрх зүйн баримт бичиг, хөгжлийн бодлого, хөтөлбөр, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион



байгуулалт, байгууллагын төсөв санхүү, техник хэрэгсэл, барилга, байгууламж, хүний нөөц, гадаад, дотоод орчны нөхцөл байдал зэрэгт дүн шинжилгээ хийж, дунд хугацаанд баримтлах стратеги зорилго, зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлов.


## **ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

Аливаа улс орны цаашдын хөгжлийн чиг хандлагыг нийгэм эдийн засаг, санхүүгийн үзүүлэлт болон улс төрийн тогтвортой байдал шууд тодорхойлж байдаг. Иймд эдгээр хүчин зүйлсийн өнөөгийн нөхцөл байдлыг товч байдлаар дурдсан болно.

### **3.1 БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хөгжил манай оронд харьцангуй сул байна. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хэмжээ хөгжиж буй орнуудад 30 гаруй хувьтай байгаа бол Монгол Улсад 9.0 хувьтай тэнцэж байгаа нь бусад орнуудтай харьцуулахад хөрөнгийн зах зээлийн хөгжил удаашралтай болохыг илтгэж байгаа хэдий ч өсөлтийн хурд эрчимтэй нэмэгдэж буй нь саашаалтай. Даатгалын салбарын гүнзгийрэлт хөгжиж буй орнуудад 2.9 хувь байгаа бол манай оронд 0.5 хувь, харин бичил санхүүгийн зах зээлийн хувьд ДНБ-ий 4.1 хувьтай тэнцүү байна.

Зураг 2. Хөрөнгийн зах зээлийн ДНБ-д эзлэх хувь /тэрбум төгрөг/



Санхүүгийн зохицуулах хороо 2020 он гэхэд хөрөнгийн зах зээлийн ДНБ-д эзлэх хувийг 15.0 болгох зорилт тавиад байна.

Өнгөрсөн хугацаанаас харахад, гадаадын иргэн, ААН-үүдийн арилжааны дүн 2012 оны 3 дугаар улирлаас хойш эрс муудаж нэг улиралд хийгдэж буй дундаж арилжаа 1.8 тэрбум төгрөг болж буурчээ. Тиймээс гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд эерэг хүлээлт үүсгэх арга замыг эрэлхийлэх шаардлагатай байв.

2015 оны 4 дүгээр улирлаас хойш буураад байсан арилжаанд оролцогч дотоодын иргэд, ААН-үүдийн арилжааны дүн сэргэх хандлага ажиглагдаж байгаа ч эдийн засаг удааширсантай холбоотойгоор хөрөнгө оруулагчид богино хугацаат, эрсдэл багатай санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол их байгааг ЗГ-ын богино хугацаат үнэт цаасны арилжааны захиалга болон биелсэн хувь хэмжээ харуулж байна.

2017 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 300 хувьцаат компани, 52 үнэт цаасны компани бүртгэлтэй байна. Даатгалын салбарт ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, ХАА-н давхар даатгалын 1 компани ажиллаж байна. Харин бичил санхүүгийн зах зээлийн хувьд 534 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа ба

дийлэнх нь буюу 90.3 хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Хадгаламж, зээлийн тусгай зөвшөөрлийн эрхтэй үйл ажиллагаа явуулж буй 290 ХЗХ байгаа бөгөөд хоршоодын нийт 55,624 гишүүдийн 57.5 хувь нь эмэгтэй гишүүд байна.

2017 онд үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2,440.2 тэрбум төгрөгт хүрсэн нь түүхэн дэх хамгийн өндөр түвшин байв. ЗЗҮ 2017 онд өмнөх оноос 65.5 хувиар өсчээ. Түүнчлэн ТОП-20 индекс өмнөх оны мөн үеийнхээс 66.5 хувиар, MSE-ALL индекс 33.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2017 онд 45.2 тэрбум төгрөгт хүрч нийт хураамжийн орлогын 31.3 хувийг эзэлж байна. Үүнээс, ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.0 хувийг бүрдүүлж байна. 2016 оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 31.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2017 онд 23.1 хувиар өсөж 969.2 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 3.6 хувьтай тэнцүү байна. Тайлант үеийн хөрөнгийн өсөлтийн 84.6 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Харин нийт зээлийн хэмжээ 2016 оноос 33.4 хувиар өсөж 638 тэрбум төгрөгт хүрсэн ба хөрөнгийн өсөлтөөс 1.4 дахин өндөр байна.

Гишүүддээ үйлчилдэг хадгаламж, зээлийн хоршооны салбарын нийт хөрөнгийн хэмжээ 153.1 тэрбум төгрөгт хүрсэн нь 2016 оны мөн үеэс 35.4 хувийн өсөлтийг үзүүлж, сүүлийн 10 жилд анх удаа 30-аас дээш хувиар өслөө. Нийт хадгаламжийн хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 47.2 хувийн өсөлтийг үзүүлэв.

Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчдийн итгэл, мэдлэг илүү нэмэгдэж байна. Хэрэглэгчдийн итгэлийн судалгааны 2018 оны 1 дүгээр улирлын үр дүнгээс үзэхэд хэрэглэгчдийн санхүүгийн байгууллагууд, тэр дундаа банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл нэмэгдэж байна гэж үнэлэгджээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн 40 гаруй хувь нь Төв банкны үйл ажиллагаанд, 20 орчим хувьд Хорооны үйл ажиллагаанд итгэдэг, харин 23 хувь нь Хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд итгэдэг гэж хариулжээ. 2017 оны 1 дүгээр улиралд хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулахад Хороо болон Хөрөнгийн биржэд итгэх итгэл багагүй хэмжээгээр нэмэгджээ. Мөн түүнчлэн Хорооны үйл ажиллагаанд итгэдэг гэсэн хариулт өмнөх улирлаас эрс нэмэгдсэн бол Хорооны үйл ажиллагааны талаар мэддэггүй иргэдийн тоо буурчээ.

### 3.2 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол улсын макро эдийн засгийн өсөлт дунд хугацаанд харьцангуй нэмэгдэж, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй байна. Үүн дээр, уул уурхайн томоохон төслүүдийн бүтээн байгуулалт 2018-2020 онд үргэлжлэн хэрэгжсэнээр тус салбарын өсөлт 2018 онд 0 хувь, 2019 онд 8.2 хувь, 2020 онд 9.9 хувьд тус тус хүрэхээр төсөөлөгдөж байна. Уул уурхайн салбарын өсөлтийн нөлөөгөөр уул уурхайн бус ДНБ-ий хэмжээ 2018 онд 6.3 хувиар, 2019 онд 5.8 хувиар, 2020 онд 3.7 хувиар тус тус өсөхөөр байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд харьцангуй тогтвортой байх хандлагатай байгаа нь эрдэс бүтээгдэхүүний үнэ тогтвортой байх боломжийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч, БНХАУ болон зарим хөгжингүй орнууд нүүрсний хэрэглээнээс татгалзаж, хэрэглээгээ бууруулах бодлого баримталж байгаа тул нүүрсний үнэ 2018-2020 онд 2017 оны үеэс буурч болзошгүй байна.

Хүснэгт 2. ДНБ-ий хэмжээ, өсөлт

	ГҮЙЦЭТГЭЛ				ТӨСӨӨЛӨЛ		
	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг)	22,227	23,150	23,935	27,167	30,662	34,383	38,019
ДНБ-ий бодит өсөлт (хувиар)	7.9	2.4	1.2	5.1	5.0	6.3	5.0
Уул уурхайн ДНБ-ий бодит өсөлт	19.4	14.1	0.2	-6.9	0	8.2	9.9
Уул уурхайн бус ДНБ-ий бодит өсөлт	5.0	-1.0	1.6	9.0	6.3	5.8	3.7

Эх сурвалж: Сангийн яам


ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд манай улсад олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 тэрбум орчим ам.долларын санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн бөгөөд уг эх үүсвэрийг төсвийн нөхцөл байдлыг сайжруулахаас гадна төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад зарцуулна. Тус хөтөлбөрийг цаашид тууштай хэрэгжүүлж, макро эдийн засгийн орчноо тогтворжуулснаар, дунд хугацаанд төлбөрийн тэнцлийн эрсдэл бага болох юм.

Дунд хугацаанд уул уурхайн болон дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор импортын хэмжээ өсөж урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэхээр байна. “Оюу Толгой” ХХК-ийн гүний уурхайн бүтээн байгуулалт, бусад уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, хөрөнгө санхүүгийн дансны ашиг нэмэгдэхээр төсөөлж байна.

2018 оны 1 дүгээр сард Чингис бонд /500 сая ам.доллар/-ын үндсэн төлбөрийг төлж барагдуулсан ба 2018-2019 онд Дим Сам бонд /1 тэрбум юань буюу 161.2 сая ам.доллар/, Кредит Свиссээс авсан зээл /300 сая ам.доллар/ зэрэг зээлүүдийн төлбөрийг төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө багатайгаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Дэлхийн зах зээл дээрх нүүрсний эрэлт 2018 онд буурах хандлагатай байгаагаас нүүрсний экспортын орлого бага зэрэг буурахаар ажиглагдаж байна. Харин Оюутолгой ордын баяжмал дахь алтны агууламж нэмэгдэж нийт экспортын хэмжээ 2018 онд 1.8 хувиар өсөж 6.3 тэрбум ам.доллар болохоор байна. Уул уурхайн томоохон үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажил үргэлжлэн явагдахтай холбоотойгоор импортын хэмжээ өсөж, 2018 онд 4.8 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 онд 11.2 тэрбум ам.долларт хүрэхээр байгаа бол гадаад худалдааны тэнцэл 1.5 тэрбум ам.доллар болно гэж төсөөлж байна.

Зураг 3. Гадаад худалдааны 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, 2018-2020 оны төсөөлөл /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: Сангийн яам

ОУВС-тай хамтран баталсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд төсөв, мөнгөний уялдаатай, зохистой бодлого хэрэгжүүлснээр макро эдийн засгийн үндсэн тэнцвэрүүд хангагдаж, инфляци зорилтот түвшинд байхаар байна. Дунд хугацаанд эдийн засгийн өсөлт нэмэгдэхээр байгаа нь эрэлтийн гаралтай инфляцийг өдөөхөөр байгаа тул, Засгийн газраас бизнесийн орчныг сайжруулах, нийлүүлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлж байгаа юм.

### 3.3 САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

Дэлхийн Эдийн Засгийн Форумаас эрхлэн гаргадаг “Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварын 2017-2018 оны тайлан”-д Монгол Улс өрсөлдөх чадварын индексийн үзүүлэлтээр 138 орноос 101 дүгээрт эрэмбэлэгдсэн нь өмнөх жилээс 1 байраар урагшилсан үзүүлэлт байлаа. Харин санхүүгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлтийн индекс нь өмнөх жилээс 0.1 нэгжээр буурч 3.0 болсноор 5 байр ухарч 129 дүгээрт жагссан байна. Үүнээс үзэхэд, Монгол Улсын санхүүгийн зах зээлийн өрсөлдөх чадвар дэлхийн улс орнуудтай харьцуулахад маш доогуур түвшинд байгаа юм.

Нийт санхүүгийн системийн бүтцийг оролцогч байгууллагуудын хөрөнгийн хэмжээгээр харьцуулан үзвэл манай улсын санхүүгийн системийн 95 орчим хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байгаа бөгөөд санхүүгийн зах зээл нь хөгжлийнхөө эхэн үед явж байгаа юм. Хэдийгээр 2017 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй 534 банк бус санхүүгийн байгууллага, 290 хадгаламж зээлийн хоршоо, 17 даатгалын компани, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 300 хувьцаат компани, 52 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил бүр олширч, үйл ажиллагааных нь цар хүрээ өргөжин тэлсээр байгаа боловч, санхүүгийн зах зээлд банкны салбартай харьцуулахад бага хувийг эзэлсэн хэвээр байна.

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл дэх хөрөнгө оруулагчдын итгэх итгэл нэмэгдэж, зах зээл дэх мэргэжлийн оролцогчид чадавхиж байгаа ба хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2018 оны 1 дүгээр улиралд өмнөх оноос 81.3 хувиар өсөж 2.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 9.0 хувьд хүрсэн юм. Нөгөө талаас, олон нийтийн санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг, боловсрол, дутмаг, мэргэжлийн оролцогчдын идэвх сул байгаа нь салбарын өсөлт, хөгжлийг сааруулах хүчин зүйл болоод байна. Тухайлбал, Үндэсний судалгаа, зөвлөгөөний төвөөс иргэдийн санхүүгийн зах зээлийн талаарх хүлээлт, санхүүгийн мэдлэг, санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг тандах зорилгоор улирал тутам хэрэглэгчдийн итгэлийн судалгааг явуулдаг. 2018 оны 1 дүгээр улиралд хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад иргэдийн 42.1 хувь нь хувьцаа, бондын арилжааг ашигтай гэж үздэг бол үлдсэн буюу талаас илүү хувь нь хувьцаа, бондын арилжааны талаар мэдэхгүй гэж хариулсан байна. Иймд банкнаас бусад санхүүгийн зах зээлийн цаашдын тогтвортой өсөлт, хөгжлийг хангахын тулд авч хэрэгжүүлэх алсын хараа, зорилго, зорилт, арга хэмжээг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

### 3.4 ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

Улаанбаатар хотод жил болгон хийгддэг Хэрэглэгчийн итгэлийн индексийн судалгаагаар иргэдийн хувьд хамгийн их санаа зовоож байгаа санхүүгийн асуудал болон санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн хүлээлтийн байдлыг гаргадаг билээ. Уг судалгаа нь иргэдийн санхүүгийн байдал, санхүүгийн байгууллагуудын талаарх мэдлэг, мэдээлэл, сонголтын талаар тандах зорилготой.

Судалгааны үр дүнгээс нийт хамрагдсан иргэдийн 33.2 хувь нь өнгөрсөн 6 сарын хугацаанд зээл авсан байна. Эндээс, орлого багатай, гэрт амьдардаг иргэд зээл авах нь их байна. Зээл

авсан иргэдийн 60 орчим хувь нь арилжааны банкнаас зээл авч байхад, 35 орчим хувь нь хувь хүмүүс болон ломбардаас зээл авдаг байна.

Иргэдийн 42.1 хувь нь хувьцаа, бондын арилжааг ямар нэг хэмжээгээр ашигтай гэж үздэг бол талаас илүү нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ. Хөдөө орон нутагт байршилтай, боловсрол багатай, гэрт амьдардаг, орлого багатай иргэдийн 60-аас дээш хувь нь энэ талаар мэдэхгүй байна.

Иргэдийн 40 гаруй хувь нь төв банкны үйл ажиллагаанд итгэдэг гэсэн байхад 20 орчим хувь нь Хорооны үйл ажиллагаанд итгэдэг, 23 хувь нь хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд итгэдэг гэж хариулжээ. Энэ нь 2017 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад нэлээд эерэгээр өөрчлөгдсөн байна. Ялангуяа Хороо болон хөрөнгийн биржид итгэх итгэл багагүй хэмжээгээр нэмэгджээ. Түүнчлэн Хороонд бага зэрэг итгэдэг гэсэн хариулт өмнөх улирлын дүнгээс эрс нэмэгдэж, харин мэдэхгүй гэсэн хариулт буурчээ.

Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийн тандах судалгаанд оролцогчдыг боловсрол, сууцны төрөл, хот хөдөө болон орлогын түвшингээр нь ангилан харахад ялгаатай дүр зураг харагдаж байгаа нь сонирхол татаж байна. Тухайлбал, боловсролын түвшин доогуур, амьжиргааны түвшин бага бүлгийн иргэд аливаа санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд итгэдэг үү гэсэн асуултад мэдэхгүй гэдэг хариултыг их өгсөн байна.

Санхүүгийн байгууллагуудтай харилцах явцад эрх зөрчигдөх тохиолдол иргэдийн ердөө 5.3 хувьд нь тохиолдож байсан гэжээ. Эдгээр иргэд эрхээ хамгаалах үүднээс гол төлөв тухайн байгууллагын удирдлагад ханддаг байна.

### 3.5 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсын эдийн засаг уул уурхайгаас хэт их хамааралтай байгаа нь түүхий эдийн үнийн өөрчлөлтийг эмзэг хүлээн авч байна. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ сэргэхгүй байгаатай зэрэгцээд ЗГ-ын зээлийн эргэн төлөлт хийх хугацаа ойртож байгаа нь эдийн засагт дарамт болох эхлэл юм. Монгол Улсын эдийн засгийн дунд хугацааны өсөлтийн талаар Сангийн яам, ОУВС, Дэлхийн банк дараах таамаглалыг дэвшүүлээд байна.

Зураг 4. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн талаарх олон улсын байгууллагуудын төсөөлөл



ОУВС-гаас хийсэн таамаглал Сангийн яам болон Дэлхийн банкнаас гаргасан таамаглалаас дээгүүр буюу харьцангуй өөдрөг байна. Манай орны эдийн засгийн бодит өсөлт 2016 оны жилийн эцэст 0.98% гарсан нь Дэлхийн банкнаас дэвшүүлсэн таамаглалтай дөхжээ.

Ийнхүү бодит сектор удаашралтай явагдаж байгаа нь санхүүгийн зах зээлд шууд нөлөөлж валютын болон банкны салбарын хямрал тохиох магадлалыг нэмэгдүүлж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, экспортын орлого сэргэхгүй байгаатай зэрэгцээд ЗГ-ын зээлийн эргэн төлөлтийн хугацаа ойртож байгаа нь ам.долларын ханшийг хөөрөгдөж валютын хямралд хүргэх магадлалыг нэмэгдүүлэв. Хэрэв зээлийн эргэн төлөгдөх хугацаагаар валютын хямрал тохиох үеийг тооцвол 2018 оны эхэн болон 2021 онд боломжтой харагдаж байна. 2018 онд эдийн засгийн өсөлт ч гэсэн 3 хувиас хэтрэхгүй байна.

Мөн бодит сектор удааширнаас үүдэн эдийн засаг дахь нийт хэрэглээ буурч санхүүгийн салбарт зээлийн чанар маш хурдан муудаж 2016 оны эцэст арилжааны банкны чанаргүй зээлийн хэмжээ 1.04 их наяд төгрөгт хүрсэн байна. ОУВС-гийн extended fund facility хөтөлбөрийг авч байгаа нь богино хугацаанд эдийн засгийн нийт эрэлтийг нэмэгдүүлэх боломжгүй хязгаарлах болно. Тиймээс зээлийн эргэн төлөлтөд асуудал үүсч, банкуудын үйл ажиллагаанд нөлөөлж хямралд хүргэх магадлалтай юм.

## **ДӨРӨВ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

### **4.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

УИХ-аас 2005 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2006 онд Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм батлагдснаар Санхүүгийн зохицуулах хороо нь банкнаас бусад санхүүгийн зах зээлд оролцогчид, зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэгтэйгээр үүсгэн байгуулагдсан.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар: Хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох бүрэн эрхтэй байдгаараа хууль тогтоох засаглалын шинжийг агуулсан, санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг шалгах зэрэг бүрэн эрхтэй байдгаараа гүйцэтгэх засаглалын шинжийг агуулсан, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон, тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй байдгаараа шүүх засаглалын шинжийг агуулсан байгууллага юм.

Өнөөдрийн байдлаар Хорооны зохицуулалтад үнэт цаасны зах зээл, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн зах зээл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршоо, зээлийн батлан даалтын сан харьяалагддаг бөгөөд тэдгээрийн 18 хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үнэт цаасны зах зээлд 52 журам, 8 заавар, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн зах зээлд 6 журам, даатгалын салбарт 57 дүрэм, журам, 7 заавар, 2 аргачлал, банк бус санхүүгийн байгууллагын салбарт 10 журам, 3 заавар, хадгаламж зээлийн хоршооны салбарт 9 журам, 4 зааврыг батлан мөрдүүлж байна.

Төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Хорооны бодлогын баримт бичиг:

Улсын хөгжлийн цогц бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, мөнгө, төсөв, санхүү хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, урт, дунд хугацааны стратегийн

баримт бичгүүдийг УИХ, Засгийн газраас хууль тогтоомжийн хүрээнд баталж хэрэгжүүлдэг.

2006-2016 онуудад тус Хороо нь дараах бодлогын баримт бичгүүдэд салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллажээ. Үүнд:

№	Төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр
1	“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого 2008-2015 он”
2	“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”
3	Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /2006-2017 онууд/
4	Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл /2006-2017 онууд/
5	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр /2004-2008/, /2008-2012/, /2012-2016/, /2016-2020/
6	Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
7	Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн 2014-2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр
8	УИХ болон Засгийн газрын тогтоолууд, УИХ-ын Байнгын хороодын тогтоол шийдвэр

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичигт Үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөх чадвар бүхий үнэт цаасыг гадаад зах зээлд гаргаж, хөрөнгийн гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх, Засгийн газрын үнэт цаасны арилжааг, ялангуяа хөрөнгө оруулалтын чиглэлээр өргөтгөх, Ипотекийн нэгтгэлийн үйл ажиллагааг жигдрүүлэх, Банк, санхүүгийн байгууллагын зах зээлд суурилсан хяналт шалгалтын удирдлагыг боловсронгуй болгох, Хадгаламжийн даатгалын эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх арга хэмжээнүүд тусгагдсан ба баримт бичгийн биелэлтийг УИХ, Засгийн газар нийтдээ 2 удаа хэлэлцэж холбогдох тайлан судалгааг гаргасан.

2015 онд Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-д Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалыг 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр хуульчилсантай нийцүүлэн “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ыг 2016-2030 онд хэрэгжүүлэхээр боловсруулсан байна. Энэхүү урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалд “Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ гэж заажээ. Санхүүгийн зах зээлд банкнаас бусад санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ” гэсэн санхүүгийн зах зээлийн олон тулгуур зохистой бүтцийг бий болгох үндсэн зорилтыг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Үүнээс гадна, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт эдийн засгийн өндөр өсөлтийг хангах санхүүгийн салбарын хөгжлийг олон улсын түвшинд ойртуулах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн салбарын хөгжлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, “Иргэндээ ээлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр олон арга хэмжээ тусгагдсаныг чиг үүргийнхээ хүрээнд Хороо хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь эдгээр баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдийг тайлант он бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж хагас бүтэн жилээр биелэлтийг гарган УИХ, Засгийн газарт тайлагнадаг бөгөөд жилдээ 15-16 баримт бичгийн 70 гаруй заалтын биелэлтийг гаргаж ирлээ.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа: Санхүүгийн зохицуулах хороо нь бодлогын асуудлуудыг шийдвэрлэх, гадны дэвшилтэт туршлагыг нэвтрүүлэхээр хамтын

ажиллагаагаа олон улсын донор байгууллага, гадны ижил чиг үүрэг бүхий байгууллага болон дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой идэвхтэй хамтран ажиллаж байна. Хороо үүсэн байгуулагдсанаас хойш гадаад хамтын ажиллагаанд онцгойлон анхаарал хандуулж ирсэн.

Хүснэгт 3. Гадаад орон болон олон улсын хамтын ажиллагаатай байгууллагууд

Олон улсын байгууллагууд		
Дэлхийн банк - WB	Олон улсын валютын сан - IMF	Азийн хөгжийн банк - ADB
Япон улсын хамтын ажиллагааны агентлаг - JICA	Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэгч олон улсын байгууллага - AII	Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг - AFI
Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг - GIZ	Олон улсын хөрөнгө оруулалтын банк - IIB	Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага - IOSCO
Даатгалын зөвлөлийн байгууллагуудын олон улсын холбоо - IAIS		
Ижил төсгэй зохицуулагч байгууллагууд		
Япон улсын FSA	Люксембург улсын HOT	Солонгос улсын FSC, FSS
Герман улсын BAFIN	Хятад улсын SRC	Казакстан улсын ARKRSFMFO
Австрали улсын ASIC	Хонконг улсын HKSF	Польш улсын FSA

Хороо нь дээрх хүснэгтэд дурдсан олон улсын байгууллагуудтай хийсэн техник тулалцааны санамж бичиг, гэрээ, хэлэлцээрийн хүрээнд зохицуулалттай этгээдүүд, хорооны боловсон хүчинг чадавхижуулах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, бодлого зохицуулалтын орчинг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бол ижил чиг үүрэг бүхий гадны байгууллагуудтай боловсон хүчинг чадавхжуулах, зах зээлийн бодлого зохицуулалтын орчинг сайжруулах, сайн туршлага, мэдээллийг харилцан солилцох замаар хамтран ажиллаж ирлээ.

Санхүүгийн зах зээлийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар эдийн засгийн өсөлтийг хүн бүрт тэгш хүргэх зорилгоор Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн гишүүнээр 2010 онд элссэн. Өнөөгийн байдлаар Хорооны төлөөлөл нийт 5 ажлын хэсэгт орж ажиллаж байгаа бөгөөд 2017 оны 9 дүгээр сард Хорооны дарга С.Даваасүрэн нь тус нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн гишүүнээр сонгогдсон юм.

Түүнчлэн санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхээр бодлого тодорхойлогч байгууллагууд болох Монголбанк, Сангийн яам, зохицуулалттай салбарын мэргэжлийн холбоод, их, дээд сургуулиудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

#### 4.2 ХҮНИЙ НӨӨЦ

Хүний нөөцийн бүтэц: Санхүүгийн зохицуулах хороо нь 2017 онд бүтцийн хувьд 7 газар, 4 хэлтэс, 2 алба, 144 орон тоотой ажиллахаас 140 албан хаагчтайгаар ажилласан. Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй зохицуулалтын байгууллагуудын нэгдсэн бүртгэл хөтөлж, шаардлагатай мэдээллүүдийг тогтоосон хугацаанд Хороонд ирүүлэх, Хорооны тогтоол шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, Хорооноос өгсөн чиглэлийн дагуу зохицуулалтын байгууллагуудад хяналт шалгалт хийх, үүрэг бүхий нийт 63 орон нутгийн төлөөлөгчид 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт ажиллаж байна.



Хүснэгт 4. СЗХ-ны албан хаагчдын бүтэц

Үзүүрэлт		Хувь
Нас	Залуучууд /30-аас доош насны/	45%
	Бусад	55%
Хүйс	Эрэгтэй	47.4%
	Эмэгтэй	52.6%
Мэргэжил	Эдийн засагч	35.5%
	Банк санхүү, санхүү, бизнесийн удирдлага	20.9%
	Эрх зүйч	16.7%
	Нягтлан бодогч	15.9%
	Олон улсын харилцаа, орчуулагч	7.2%
	Багш, сэтгэл зүйч	5.1%
	Мэдээллийн технологич	3.6%
	Хэрэглээний математик, эдийн засгийн математикч	2.9%
	Сэтгүүлч, улс төр судлаач, аялал жуулчлал	0.7%
	Инженер	0.7%

Санхүүгийн зохицуулах хорооны 11 газар, хэлтсийн нийт 103 мэргэжилтэн, албан хаагчид судалгаанд цахим хэлбэрээр хариулан идэвхтэй оролцсон бөгөөд түүврийн хувьд нийт 144 албан хаагчдыг төлөөлж чадсан гэж үзлээ.

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр нь ангилвал 40-өөс 60 хүртэлх насны албан хаагчид 16 хувь буюу харьцангуй бага хувийг эзэлж байгаа бол 30-аас доош насны залуучууд 50 орчим хувийг эзэлж байна. Судалгаанаас харахад Хорооны нийт ажиллагсдын дундаж нас 31.9 байна.

Судалгаанд оролцогчдын 54.4 хувь нь эрэгтэй, 45.6 хувь нь эмэгтэй байсан бөгөөд боловсролын түвшингийн хувьд 56.3 хувь нь бакалавр, 39.8 хувь нь магистр зэрэгтэй бол 1.9 хувь нь доктор зэрэгтэй байна.

2016 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт албан хаагчдын 39 хувь нь 1 хүртэлх жил, 17 хувь нь 1.1-ээс 3 жил, 23 хувь нь 3.1-ээс 6 жил, 11 хувь нь 6.1-ээс 10 жил, үлдсэн 11 хувь нь 10-аас дээш жил тус тус Хороонд ажилласан байна.


Нөхцөл байдлын үнэлгээ: Хорооны одоогийн нөхцөл байдалд өгч буй мэргэжилтэн, албан хаагчдын үнэлгээг 1-5 хүртэл оноогоор үнэлсэн. /сайн бол-5, муу бол-1/ Асуулгын үр дүнг харахад нийт албан хаагчдын дийлэнх хувь нь өөрийн ажиллах чиг үүргээ сайн мэддэг гэж үнэлэгдсэн тул Хорооны бүтэц зохион байгуулалт, ажиллагсдын ур чадварыг үнэлэх байдал сайн байна гэж дүгнэгдлээ.

Зураг 5. Хорооны одоогийн нөхцөл байдлын талаар 1-5 хүртэл онооны үнэлгээ (1 - маш муу, 5 - маш сайн)



Харин Хорооны газар, хэлтэс тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, материал хангамжийн байдал, ажиллагсад үзүүлэх нийгмийн халамжийн байдалд дийлэнх хувь нь дунд буюу муу гэж хариулсан байна.

Зураг 6. Чиг үүрэгтэй холбоотой ажлын давхардал 1-5 хүртэл онооны үнэлгээ



Ажлын чиг үүрэгтэй холбогдох давхардал дундаас доош байгаа гэж 79 хувь нь үзсэн бол харин давхардал маш их болон их гэсэн сонголтод 21 хувь байгаагаас үзвэл ажлын давхардал харьцангуй бага байна. Ажлын байрны чиг үүргээ мэдэх эсэх үнэлгээнд хамгийн өндөр дундаж үнэлгээ өгсөн дүгнэлттэй харьцуулж үзвэл Хорооны чиг үүрэг сайн тодорхойлогдсон гэж дүгнэж болох юм.

Хүний нөөцийг чадавхжуулах: Сүүлийн нэг жилийн хугацаанд албан хаагчдын сургалтад хамрагдсан байдлаас харвал ажиллагсдын дотоодын сургалтад хамрагдсан байдал гадаад улсаас харьцангуй их байна. Хорооны нэг ажилтан жилд дунджаар Монгол Улсад 4.14 удаа сургалтад хамрагдсан бол гадаад улсад 1.5 удаа хамрагдсан байна.

Зураг 7. Хорооны албан хаагчдын сүүлийн нэг жилийн хугацаанд хорооны үйл ажиллагаанд холбогдолтой Монгол Улс болон гадаадын улс оронд сургалтад хамрагдсан байдал



Нийт 103 ажилтны 37 хувь нь Монгол Улсад огт сургалтад хамрагдаагүй буюу эдгээр нь 1 жил хүртэл ажиллаж буй шинэ боловсон хүчин, харин гадаад улсад 83 хувь нь огт хамрагдаагүй. Цаашид мэдлэг ур чадвараа дээшлүүлэх хүсэлтэй байгаа гэж 96.1 хувь нь хариулсан байна. Тиймээс ирэх жилүүдийн хэтийн төлөвлөгөөнд Хорооны ажилчдыг сургалтад хамрагдах талаар түлхүү анхаарал хандуулснаар албан хаагчдын мэдлэг чадвар, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх боломжтой.

#### 4.3 ХАНГАМЖ

Нөхцөл байдлын үнэлгээ: 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар Хороо нь нийт 1.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй бөгөөд үүнээс 0.9 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 55-аас дээш хувь нь элэгдэлд орсон байна. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд ажилчдынхаа суурин компьютер, хяналт шалгалтад шаардлагатай техник хэрэгсэл, зөөврийн компьютер, тавилга эд хогшлийг сайжруулах, шинэчлэх шаардлагатай байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн хураангуй тайлан

Хөрөнгө	Тоо	Нийт хөрөнгийн үнэлгээ	Элэглэл	Хувь
Автомашин	7	314,598,984.60	198,108,266.17	63%
Компьютер /суурин, зөөврийн, бусад/	207	314,575,335.99	218,541,716.92	69%
Компьютерийн бусад тоног төхөөрөмж	267	112,169,394.65	59,009,274.13	53%
Принтер, скайнер, проектор, телефон аппарат	135	80,398,764.02	47,355,504.09	59%
Програм хангамж	23	516,032,354.38	244,707,376.01	47%
Камер, дуу хураагуур	18	11,760,110.08	4,754,275.97	40%
Тавилга, эд хогшил	714	166,911,093.06	80,297,623.60	48%
Бусад цахилгаан хэрэгсэл	55	25,916,633.10	21,258,240.71	82%
<b>Нийт</b>	<b>1426</b>	<b>1,542,362,669.88</b>	<b>874,032,277.60</b>	<b>57%</b>

Үүнээс хэрэглээнд байгаа нийт 141 суурин компьютерээс хамгийн хуучин нь 2006 оных, хамгийн сүүлийн үеийнх нь 2014 оны компьютер байгаа нь ашиглалтын хугацаа дууссан, ажлын шаардлагад нийцэхгүй болсныг илтгэж байна.

Судалгааны явцад сайжруулах шаардлагатай компьютер хамгийн их хувийг эзэлж байсан шалтгаан нь Хорооны компьютеруудын үзүүлэлт харьцангуй шаардлага хангахгүй, хоцрогдсон буюу удаан, яаралтай үед програмууд гацдаг, ачааллаа дийлдэггүй гэсэн байв.


Харин програм хангамжийн хувьд тухайн газар, хэлтсийн ажилтнуудын майкрософт програмууд өөр хоорондоо файл зөөхөд (Жишээлбэл: MS2007, MS2013 хоорондоо зөрчилдөх) өөрчлөгдөж очих зэрэг асуудал үүсдэг байна.

Хангамжтай холбоотой тулгарч буй бэрхшээл: Санал асуулгаар Хорооны албан хаагчдаас ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд ямар ямар бэрхшээлүүд тулгардаг вэ, хэрэглэж буй техник, програм хангамжаас сайжруулах шаардлагатай зүйл байгаа эсэх талаар асуухад дараах дүр зураг ажиглагдлаа.

Зураг 8. Хорооны албан хаагчдын ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд тулгардаг бэрхшээл



Зураг 9. Хэрэглэж буй техник, програм хангамжаас сайжруулах шаардлагатай



Судалгааны үр дүнгээс харахад олон сонголттой хариултад давхардсан тоогоор нийт 176 хариулт ирснээс Хорооны нийт албан хаагчдын дийлэнх хэсэгт буюу 76.3 хувьд нь ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд бэрхшээл тулгардаг гэсэн байна. Эдгээр бэрхшээлүүдээс дурдвал, ажлын ачаалал их, техник хангамж, төсвийн хүрэлцээ, ажлын хуваарилалт тэгш бус, шууд удирдлагын тохиромжгүй арга барил зэрэг бэрхшээлүүд тулгарч байгаагаас гадна нийт албан хаагчдын 32 хувь нь компьютер, 26 хувь нь интернетийн хурд, 19 хувь нь принтер, 14 хувь нь програм хангамж дутагдалтай гэж хариулсан байна.

#### 4.3 ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ


Сүүлийн жилүүдэд Хорооны үйл ажиллагааны чиг үүрэг, зах зээлийн хамрах хүрээ, зохицуулалтын үйл ажиллагаа нэмэгдсээр байтал төсвийн зардал жил тутам буурч Хороо хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл учраад байна. Хорооны зохицуулалттай байгууллагуудын тоо 2013 онтой харьцуулахад 2.7 дахин өссөн байна.

Зураг 10. Хорооны батлагдсан төсөв болон ОУ-ын төсөл хөтөлбөр, тусламж



2015 онд эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй эерэг үзүүлэлттэй, мөн “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” төсөл хэрэгжсэнтэй холбоотойгоор төсөв өндөр батлагдаж байсан. Төсвийн зардлыг хэмнэх, ажлын давхардлыг арилгах, үр ашиггүй зардлыг бууруулах, хэмнэлтийн зарчмаар ажиллах УИХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх шаардлагаар Төсвийн тухай хуулиар Хорооны даргын багцад батлагдсан төсөв 2016, 2017 онуудад жил дараалан буурч батлагдсан. 2016 онд Хорооны төсөв өмнөх оноос 15 хувь, 2017 онд өмнөх оноос 7 хувиар танагдаж 2.5 тэрбум төгрөгөөр батлагдсан юм.

Зураг 11. 2017 оны төсөвт зардлын хуваарилалт




2017 онд нийт төсвийн 71 хувь нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 12 хувь нь байр ашиглалт, байрны түрээсийн зардалд, 11.8 хувь нь олон улсын гишүүнчлэлийн хураамжийн зардалд зарцуулагдаж, үйл ажиллагааны бусад урсгал зардалд 5.2 хувь буюу 130.7 сая орчим төгрөг хуваарилагдаж бичиг хэрэг, шуудан холбоо, шатахуун, авто машины засвар үйлчилгээнд зориулагдсан.

Зураг 12. Хорооны үндсэн хөрөнгийн хангамж



2016 оны 4 дүгээр улирлын байдлаар Хороо 1,800.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, нийт хөрөнгийн 58.7 хувь нь элэгдлээрээ анхны үнээ нөхсөн, ажлын шаардлагад нийцэхгүй, ашиглалтын хугацаа дууссан байна.

Зураг 13. Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийн ангилал



Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт хөрөнгийн 37.7 хувь нь компьютер, 17.7 хувь нь тавилга эд хогшил, 27.2 хувь нь биет бус, бусад ангиллын үндсэн хөрөнгө байна. Иймд Хороо компьютер, тавилга эд хогшилоо сайжруулах нэн шаардлага үүсээд байна.

Шийдвэрлэх, анхаарах асуудлууд: Төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараах ажлууд хийгдэхэд хүндрэл тулгарч байна. Үүнд:

- Санхүүгийн зах зээлд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, салбарын мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, хууль дүрмийг сурталчилах, олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- Хадгаламж, зээлийн хоршооны чиглэлээр нэг хянан шалгагч 50-60 ХЗХ, Үнэт цаасны чиглэлээр нэг хянан шалгагч 60 ХК, 12 ҮЦК, Даатгалын чиглэлээр нэг хянан шалгагч 4 даатгалын компани, 12 даатгалын мэргэжлийн оролцогчийн компани, Банк бус санхүүгийн чиглэлээр нэг ажилтан 60-100 банк бус санхүүгийн байгууллага хариуцан ажиллаж байна. Иймд нэг албан хаагчид оногдох ажлын ачааллыг бууруулах, орон тоог нэмэгдүүлэх;
- Албан хаагчдыг мэргэшүүлэх, хувь хүний ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг солилцох дотоод, гадаад сургалтуудыг тогтмол зохион байгуулах;

- Үндсэн хөрөнгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, техник технологийн шаардлага хангахгүй компьютер тоног төхөөрөмжөөр албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байгаа зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд Хорооны төсвийг нэмэгдүүлэх.

#### 4.4 СВОТ ШИНЖИЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд хийсэн гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээний үр дүнг дор үзүүлэв.

Боломж ба давуу тал:

БОЛОМЖ:	ДАВУУ ТАЛ:
<ul style="list-style-type: none"> <li>✓ Хорооны төсөвт төвлөрүүлэх орлого нь Зохицуулалтын үйлчилгээний хөлс, Улсын тэмдэгтийн хураамжаас бүрддэг</li> <li>✓ ОУ-ын болон бусад орнуудын зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлсэн, техник туслалцаа авах боломж бүрдсэн</li> <li>✓ Тодорхой даатгалын бүтээгдэхүүнийг арилжааны даатгалын компаниудаар дамжуулан хийлгэж байгаа нь салбарын өсөлтийг дэмжиж байна</li> <li>✓ Монголбанк, Сангийн яам болон зохицуулалттай салбарын мэргэжлийн холбоодтой санамж бичиг байгуулсан</li> <li>✓ “МХБ” ХК-д өөрийгөө зохицуулах байгууллагын зөвшөөрөл олгон, олон нийтэд үнэт цаас гаргахтай холбоотой бүртгэх эрхийг шилжүүлсэн</li> <li>✓ Хороо нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/, Олон улсын даатгалын зохицуулалт, хяналтын байгууллага /AIS/ болон Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн гишүүн бөгөөд тэдгээрийн стандартыг зохицуулалттай зах зээлд хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Үйл ажиллагаа явуулах дүрэм, журам, эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн</li> <li>✓ Байгууллагын дотоод журмыг баталж мөрдүүлж байгаа</li> <li>✓ Байгууллагын соёл тодорхой хэмжээнд төлөвшсөн</li> <li>✓ Үйл ажиллагааны график төлөвлөлтийг мэргэжилтнээс эхлээд газар, хэлтэс, хорооны түвшинд жил, улирал, сараар төлөвлөн гүйцэтгэлд нь хяналт тавьдаг</li> <li>✓ Хүний нөөцийн нөхөн хангалт тодорхой хэмжээнд хийгдэж мэргэжлийн боловсон хүчнээр хангах бодлогыг тууштай хэрэгжүүлж байна</li> <li>✓ Жил бүр гадаад, дотоодод богино хугацааны сургалтад албан хаагчдыг сургаж мэргэшүүлж байна.</li> <li>✓ Олон улсын, бусад төсөл хөтөлбөр, санхүүжилтээр техник технологийг сайжруулах</li> </ul>

Эрсдэл ба сул тал:

ЭРСДЭЛ:	СУЛ ТАЛ:
<ul style="list-style-type: none"> <li>✓ Хорооны төсөв төсвөөс голчлон хамаардаг, гэвч улс орны эдийн засгийн чадавхи сул, төсвөөс шалтгаалан шинэ техник технологи нэвтрүүлэх боломж хязгаарлагдмал</li> <li>✓ Банкны салбартай харьцуулахад банкнаас бусад санхүүгийн зах зээл дээр ажиллаж буй хүний нөөцийн чадавхи сул</li> <li>✓ Улс төрийн нөлөөллөөс шалтгаалж хүний нөөцийн бодлогын тогтвортой байдал алдагдах, бодлого шийдвэр хэрэгжихэд саад болох</li> <li>✓ Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц хөгжөөгүй</li> <li>✓ Иргэдийн санхүүгийн мэдлэг дутмаг</li> <li>✓ Санхүүгийн байгууллагууд нэгдэх, охин компани байгуулах замаар санхүүгийн групп компаниудыг үүсгэж байгаа нь системийн эрсдэл үүсгэх магадлалтай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хяналтын системийг сайжруулах, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой боловсронгуй болгох шаардлагатай</li> <li>✓ Сургаж, мэргэшүүлсэн болон чадварлаг хүний нөөцдөө хангалттай цалин урамшуулал олгож чаддаггүй улмаас тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй, тэдгээрийн нийгмийн баталгаа хангагдаагүй.</li> <li>✓ Удирдлага солигдох бүрт бүтэц, орон тоо өөрчлөгдөж, хүний нөөцийн байршил алдагддаг</li> <li>✓ Ажлын байрны орчин нөхцөл, техник хангамж ажлын шаардлагад нийцээгүй.</li> <li>✓ Зохицуулалтын салбарын нэгдсэн мэдээллийн сан үүсээгүйн улмаас ялгаатай мэдээлэл ашиглах, мэдээллийн ил тод байдал хангагддаггүй.</li> </ul>

**Давуу талаараа эрсдэлийг бууруулах арга хэмжээ:**

Шинэчилсэн стратеги төлөвлөгөө нь тогтвортой бодлогоор, нэгдсэн зарчмаар нэг зорилгын хүрээнд ажиллаж 2019-2021 онуудад зорилтот түвшиндээ бүрэн хэрэгжсэнээр дараах эрсдэлийг бууруулах бүрэн боломжтой.

- ✓ Бичил санхүүгийн салбарын давуу талыг ашиглан хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж, хүртээмжийг эрчимтэй сайжруулах;
- ✓ Гадаадад богино хугацааны сургалтад суусан албан хаагчдын туршлагаас суралцаж иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг 60 хувиар нэмэгдүүлэх;
- ✓ Хөрөнгийн зах зээлийн өсөлтийг хадгалж, дэд бүтцийг зөв бодлогоор хөгжүүлж дэмжих;
- ✓ Санхүүгийн олон тулгуурт бус тогтолцоо буюу банк давамгайлсан байдлыг бууруулж банкнаас бусад салбарын чадавхыг дээшлүүлж эдийн засаг, нийгэмд өгөх өгөөжийг 50 хувиар нэмэгдүүлэх;

**Боломжуудаараа сул талаа арилгах:**

СВОТ шинжилгээний боломжуудаа ашиглан сул талаа арилгах аргыг хэрэгжүүлснээр давуу талуудаа нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

- ✓ СЗХ-ны нэгдсэн мэдээллийн санг үүсгэснээр зах зээлд гаргаж буй зөрүүтэй мэдээллийг арилгах, мэдээллийн ил тод байдлыг хангах;
- ✓ Олон улсын болон бусад орнуудын төсөл хөтөлбөр, санхүүжилтээр техник хангамжаа сайжруулснаар аюулгүй байдлаа нэмэгдүүлж технологийн доголдолгүй болох;
- ✓ Олон улсын зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлснээр албан хаагчдаа сургаж, мэргэшүүлж, чадавхжуулснаар чадварлаг, тогтвор суурьшил бүхий хүний нөөцийг бий болох;
- ✓ Гишүүн байгууллага болох олон улсын томоохон үнэт цаас зэрэг байгууллагуудын стандартыг нэвтрүүлснээр хяналтын системийг зөв бүтэцтэй хэрэгжүүлж эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг бий болгох боломжтой;
- ✓ Хөдөө орон нутаг болон газарзүйн байршлаар алслагдмал оршин буй харилцагчдад хүрч үйлчлэх тэдгээрийн бичил болон жижиг дунд бизнест хөнгөлөлттэй санхүүжилт олгох замаар олон улсын хөнгөлөлттэй зээл тусламжийг дамжуулан зээлдүүлэх;



## ТАВ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨГӨӨ (2018-2021)

### АЛСЫН ХАРАА (VISION)

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО (MISSION)

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

### ҮНЭТ ЗҮЙЛС (VALUE)

1. **Цогц мөн чанар:** Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;
2. **Хариуцлагатай байх:** Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;
3. **Мэргэжлийн байх:** Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;
4. **Бие даасан байх:** Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;
5. **Манлайлал, санаачлагатай байх:** Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;
6. **Багаар ажиллах:** Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

**БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ ЮМ.**

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО НЬ НЭГДСЭН БОДЛОГЫН  
ДОР ДАРААХ 6 ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ**

**ЗОРИЛГО 1: ДАНГААР НОЁРХОЛГҮЙ, ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ, ТЭГШ БОЛОМЖ БҮХИЙ ШУДАРГА, ЧӨЛӨӨТ ӨРСӨЛДӨӨНТ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ.**

**Стратегийн зорилт 1.1.** Зах зээлд нэвтрэх саад бэрхшээлийг бууруулж, оролцогчдыг тэгш боломжоор хангах

*Дэд зорилт 1.1.1.* Санхүүгийн салбарт өрсөлдөөнийг дэмжсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

*Дэд зорилт 1.1.2.* Зах зээлд оролцогчдод тавигдах нөхцөл, шаардлагыг үйл ажиллагааны онцлогтой уялдуулан оновчтой тогтоох, хөнгөвчлөх замаар тэдгээрийг дэмжих;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ /ХҮРЭХ ҮР ДҮН /	
✓	Бизнесийн таатай орчин бүрдэж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоо 20 хувиар буурсан байна.* <sup>1</sup>
✓	Зохицуулалтын байгууллагуудын өрсөлдөх чадвар 50 хувиар нэмэгдсэн байна.
✓	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох хүсэлтийг шийдвэрлэх дундаж хугацаа 40 хувиар буурсан байна.

**Стратегийн зорилт 1.2.** Санхүүгийн зах зээлд оролцогчдын мэдээллийн үнэн зөв, ил тод, нээлттэй байдлыг хангуулах замаар санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх

*Дэд зорилт 1.2.1.* Зах зээлд оролцогчдын бизнесийн хариуцлагыг сайжруулах замаар санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод нээлттэй байдлыг хангуулах;

*Дэд зорилт 1.2.2.* Санхүүгийн зах зээлийн харилцагчдад үнэн зөв мэдээллээр хангахад чиглэсэн ёс зүйн хэм хэмжээ төлөвшүүлэх;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Зохицуулалттай байгууллагуудын харилцагчдаас ирж буй өргөдөл, гомдлын тоо 40 хувиар буурсан байна.
✓	Банкнаас бусад санхүүгийн зах зээлд оролцогчдын итгэл сайжирч, харилцагчдын тоо 50 хувиар нэмэгдсэн байна.
✓	Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн тоо 40 хувиар нэмэгдсэн байна.

№	ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН
1	Бизнесийн таатай орчин бүрдэж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоо 20 хувиар буурсан байна.*	5%	10%	15%	20%
2	Зохицуулалтын байгууллагуудын өрсөлдөх чадвар 50 хувиар нэмэгдсэн байна.	10%	20%	30%	50%
3	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох хүсэлтийг шийдвэрлэх дундаж хугацаа 40 хувиар буурсан байна.	5%	15%	30%	40%
4	Зохицуулалттай байгууллагуудын харилцагчдаас ирж буй өргөдөл, гомдлын тоо 40 хувиар буурсан байна.	10%	20%	30%	40%

<sup>1</sup>\*Суурь он 2017 /бүх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн суурийг 2017 оноор тооцно./

5	Банкнаас бусад санхүүгийн зах зээлд оролцогчдын итгэл сайжирч, харилцагчдын тоо 50 хувиар нэмэгдсэн байна.	10%	20%	30%	50%
6	Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн тоо 40 хувиар нэмэгдсэн байна.	10%	20%	30%	40%

**ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЭМЖИХ СХЕМ БҮТЭЦ: 1**



**ЗОРИЛГО 2: ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШИГ ХАМГААЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ**

**Стратегийн зорилт 2.1.** Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах болон мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх

**Дэд зорилт 2.1.1.** Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчинг сайжруулах;

**Дэд зорилт 2.1.2.** Харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

**Дэд зорилт 2.1.3.** Санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, барагдуулах үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Хөрөнгө оруулагч, харилцагчийн санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг 40 хувиар нэмэгдүүлнэ.
✓	Хороонд ирсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг цахим системд оруулж, мэдээллийн бааз үүсгэсэн байна.

**Стратегийн зорилт 2.2.** Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх

**Дэд зорилт 2.2.1.** Иргэдийн хувийн санхүүгээ удирдах, санхүүгийн залилангаас хамгаалах чадварыг эзэмшүүлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

**Дэд зорилт 2.2.2.** Иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр санхүүгийн зах зээлд оролцогч талуудын үр нөлөө бүхий хамтын ажиллагааг бэхжүүлэх;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Иргэдийн хувийн санхүүгийн суурь мэдлэгийн түвшинг 40 хувиар нэмэгдүүлнэ.

№	ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН
1	Хөрөнгө оруулагч, харилцагчийн санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх хувь	5%	15%	25%	40%
2	Хороонд ирсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг цахим системд оруулж, мэдээллийн бааз үүсгэсэн байна.	25%	50%	70%	100%
3	Иргэдийн хувийн санхүүгийн суурь мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх хувь	10%	15%	25%	40%

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЭМЖИХ СХЕМ БҮТЭЦ: 2



### **ЗОРИЛГО 3: САНХҮҮГИЙН БҮХ ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ ХЯМД, ХЯЛБАР, ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ**

**Стратегийн зорилт 3.1.** Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тогтолцоог бэхжүүлэх

**Дэд зорилт 3.1.1.** Санхүүгийн хүртээмжийг сайжруулах бодлогын баримт бичиг боловсруулж хэрэгжүүлэх;

**Дэд зорилт 3.1.2.** Санхүүгийн зах зээлд оролцогчдын чадавхийг нэмэгдүүлэх;

**Дэд зорилт 3.1.3.** Хямд эх үүсвэртэй, урт хугацаат зээл болон бусад санхүүгийн хэрэгслийг зах зээлд гаргахыг бодлогоор дэмжих;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Зохицуулалттай байгууллагуудын зээлийн жигнэсэн дундаж хүүг 30 хүртэлх хувиар бууруулсан байна.
✓	Мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж сертификат эрх авсан этгээдийн тоог 3 дахин нэмэгдүүлсэн байна.
✓	Засгийн газар, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд хамрагдалтын тоог 4 дахин нэмэгдүүлсэн байна.

**Стратегийн зорилт 3.2.** Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх

**Дэд зорилт 3.2.1.** Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

**Дэд зорилт 3.2.2.** Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой үүсэх эрсдэлийг хянах тогтолцоог бий болгох;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэгчдийн тоог 5 дахин нэмэгдүүлнэ.
✓	Технологид суурилсан зохицуулалтын (Сэндбокс(Sandbox), рэгтек(Regtech)) орчинг бүрдүүлсэн байна. Рэгтек нь зохицуулалтын ерөнхий ойлголт, сэндбокс нь түүнийг хэрэгжүүлэх нэг төрлийн арга хэрэгсэл гэдгийг анхаарна уу?

№	ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН
1	Зохицуулалттай байгууллагуудын зээлийн жигнэсэн дундаж хүүг 30 хүртэлх хувиар бууруулсан байна.	5%	10%	15%	30%
2	Мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж сертификат эрх авсан этгээдийн тоог 3 дахин нэмэгдүүлсэн байна.	0.5 дахин	1 дахин	2 дахин	3 дахин
3	Засгийн газар, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд хамрагдалтын тоог 4 дахин нэмэгдүүлсэн байна.	0.5 дахин	2 дахин	3 дахин	4 дахин
4	Дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэгчдийн тоог 5 дахин нэмэгдүүлнэ.	0.5 дахин	1 дахин	3 дахин	5 дахин
5	Технологид суурилсан зохицуулалтын ((Сэндбокс (Sandbox), рэгтек (Regtech)) орчинг бүрдүүлсэн байна.	10%	30%	70%	100%

### ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЭМЖИХ СХЕМ БҮТЭЦ: 3



**ЗОРИЛГО 4: САНХҮҮГИЙН САЛБАР ХООРОНДЫН УЯЛДАА ХОЛБООГ ХАНГАЖ, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРСДЭЛИЙГ ТАРХААН БАЙРШУУЛЖ, БУУРУУЛАХ ЗАМААР САНХҮҮГИЙН ОЛОН ТУЛГУУРТ БҮТЦИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ.**

**Стратегийн зорилт 4.1.** Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж санхүүгийн зах зээлийг тэлэх

**Дэд зорилт 4.1.1.** Санхүүгийн зах зээл хоорондын уялдааг хангах чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах;

**Дэд зорилт 4.1.2.** Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үр өгөөжтэй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэлэг санааг зохицуулалтын бодлогоор дэмжих;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үр өгөөжтэй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг 20 хувиар нэмэгдэнэ.

**Стратегийн зорилт 4.2.** Санхүүгийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах

**Дэд зорилт 4.2.1.** Эрсдэлийг тархаан байршуулж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх;

**Дэд зорилт 4.2.2.** Зохицуулалттай байгууллагуудын засаглалыг сайжруулах замаар санхүүгийн байгууллагуудыг төлөвшүүлэх;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрэн нэвтрүүлсэн байна.
✓	Зохицуулалттай байгууллагуудын засаглалын түвшинг 20 хувиар сайжруулсан байна.

№	ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН
1	“Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үр өгөөжтэй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэлэг санаа” нэмэгдэгдүүлэх хувь	5%	10%	15%	20%
2	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрэн нэвтрүүлсэн байна.	*	25%	50%	100%
3	Зохицуулалттай байгууллагуудын засаглалын түвшинг сайжруулах хувь	5%	10%	15%	20%

\* Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журам, заавар, аргачлал, програм хангамж бэлтгэсэн байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЭМЖИХ СХЕМ БҮТЭЦ: 4



**ЗОРИЛГО 5: ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХООРОНД САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ҮР АШИГТАЙ УРСГАЛ БҮХИЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЖ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ.**

**Стратегийн зорилт 5.1.** Санхүүгийн зах зээлд учирч болох эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх

*Дэд зорилт 5.1.1.* Санхүүгийн зах зээлийн эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, урьдчилан таамаглах арга, аргачлалыг нэвтрүүлэх;

*Дэд зорилт 5.1.2.* Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр зохицуулалтын орчныг бүрдүүлэх;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Зах зээлийн системийн эрсдэлийг салбар тус бүрт 30 хувь бууруулсан байна.
✓	Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд гарч буй зөрчлийн тоо хэмжээ 40% бууруулсан байна.

**Стратегийн зорилт 5.2.** Санхүүгийн зах зээлд нөөцийн оновчтой удирдлагын тогтолцоог хөгжүүлэх

*Дэд зорилт 5.2.1.* Санхүүгийн зах зээлд нөөцийн урсгалыг тасралтгүй, үр ашигтай, зохистой удирдах мэргэжлийн оролцогчдыг бий болоход бодлогоор дэмжих;

*Дэд зорилт 5.2.2.* Урт хугацааны мэргэжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих таатай орчин бүрдүүлэх;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн оролцогчдын тоог 30% нэмэгдүүлсэн байна.



№	ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН
1	Зах зээлийн системийн эрсдэлийг салбар тус бүрт бууруулах хувь	*	10%	15%	30%
2	Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд гарч буй зөрчлийн тоо хэмжээг бууруулах хувь	10%	15%	25%	40%
3	Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн оролцогчдын тоог нэмэгдүүлэх хувь	5%	10%	20%	30%

\* Эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, урьдчилан таамаглах арга, аргачлалыг боловсруулсан байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЭМЖИХ СХЕМ БҮТЭЦ: 5



**ЗОРИЛГО 6: САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭГЧ, ДЭМЖИГЧ, ХАРААТ БУС, ИТГЭЛ ХҮЛЭЭСЭН, ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА БАЙХ**

**Стратегийн зорилт 6.1.** Нэг зорилго руу тэмүүлсэн хамт олонтой, хүний нөөцийн идэвхжүүлэлт болон хяналтын зохистой тогтолцоог бий болгох

*Дэд зорилт 6.1.1.* Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянах шалгуур үзүүлэлт тогтоож, урамшууллын механизмыг нэвтрүүлэх.

*Дэд зорилт 6.1.2.* Дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх.

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Хорооны албан хаагчдын 80 хувийг гадаад, дотоодын сургалтад хамруулсан байна.
✓	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн тогтолцоог бүрэн нэвтрүүлнэ.
✓	“Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ыг дотоод аудитын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна.

**Стратегийн зорилт 6.2:** Мэдээллийн цогц дэд бүтцийг бий болгох, ил тод байдлыг хангах

*Дэд зорилт 6.2.1.* Нууцлал, аюулгүй байдлыг хангасан нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх;

*Дэд зорилт 6.2.2.* Олон нийтэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх.

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Нэгдсэн мэдээллийн сангийн цогц системийг бүрэн нэвтрүүлсэн байна.
✓	Мэдээ, мэдээллийн давтамж, сувгийг 2 дахин нэмэгдүүлнэ.

**Стратегийн зорилт 6.3.** Хамтын ажиллагааг өргөжүүлэх, идэвхижүүлэх

*Дэд зорилт 6.3.1.* Олон улс, бүс нутгийн хэмжээний санхүүгийн зах зээлийн институцийн олон талт үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, байр сууриа бэхжүүлэх;

*Дэд зорилт 6.3.2.* Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой харилцан үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	
✓	Олон улсын байгууллагуудын техник туслалцаа, хамтын ажиллагааны 4-өөс доошгүй төслийг хэрэгжүүлсэн байна.
✓	Хамтран ажиллах санамж бичгийн тоог 2 дахин нэмэгдүүлж, хэрэгжилтийн биелэлтийг 100 хувьд хүргэсэн байна.

№	ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН
1	Хорооны албан хаагчдын 80 хувийг гадаад, дотоодын сургалтад хамруулсан байна.	20%	35%	60%	80%
2	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн тогтолцоог бүрэн нэвтрүүлнэ.	25%	50%	75%	100%
3	“Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-ыг дотоод аудитын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна.	25%	50%	75%	100%

4	Нэгдсэн мэдээллийн сангийн цогц системийг бүрэн нэвтрүүлсэн байна.	25%	50%	75%	100%
5	Мэдээ, мэдээллийн давтамж, сувгийг 2 дахин нэмэгдүүлнэ.	-	0.5 дахин	1 дахин	2 дахин
6	Олон улсын байгууллагуудын техник туслалцаа, хамтын ажиллагааны 4-өөс доошгүй төслийг хэрэгжүүлсэн байна.	-	2	3	4
7	Хамтран ажиллах санамж бичгийн тоог 2 дахин нэмэгдүүлж, хэрэгжилтийн биелэлтийг 100 хувьд хүргэсэн байна.	-	0.5 дахин	1 дахин	2 дахин

## **ЗУРГАА. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

### **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлагын чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, ажлын алба хариуцаж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд стратеги зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг, төсвийн хамт төлөвлөж жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж өгнө.

#### **ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ БА ХУГАЦАА:**

I үе шат: 2018 он-2019 он

II үе шат: 2019 он-2020 он

III үе шат: 2020 он-2021 он

#### **ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ:**

Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөс гадна гадаад дотоодын хандив, тусламж хийгээд бусад хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, биелэлтийг гаргах, тайлагнах асуудлыг Захиргааны удирдлагын газар хариуцна.

#### **СТРАТЕГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ:**

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж үнэлгээ өгөхдөө дараах алхмуудыг баримталж ажиллана. Үүнд:

1. Үр дагавар, зорилтыг тодорхойлох;
2. Хяналт-шинжилгээ хийх үр дагаврын үзүүлэлтүүдийг сонгох;
3. Тухайн нөхцөл байдлын суурь үзүүлэлтийн талаарх мэдээлэл цуглуулах;
4. Тодорхой зорилтот түвшин, тэдгээрт хүрэх хугацааг тогтоох;
5. Зорилтот түвшинг хангаж байгаа эсэхийг үнэлж дүгнэх үүднээс тоо мэдээ тогтмол цуглуулах;
6. Үр дүнд шинжилгээ хийж, тайлагнах.

Дээрх алхмуудыг баримталж үр дүнд суурилсан Хяналт, шинжилгээ, үнэлгээ-ний тогтолцоог бүрэн нэвтрүүлж үйлчилгээний чанар, үр ашиг, бүтээмжийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны Дотоод аудитын хэлтэс нь бусад газруудтай хамтран стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах, зорилтот төсөл хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээнд тулгуурлан мэдээлэл цуглуулах, бодлогын дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, үйл ажиллагааг засч чиглүүлэх, тайлагнах үүрэг хүлээнэ.

Стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж байгаа зорилтот төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн төсөл, хөтөлбөрийн зорилго, зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаанаас хамааран тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат бүрийн төгсгөлийн жилд тухайн шатанд тавьсан стратеги зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

#### СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТОДОТГОЛ ХИЙХ

Жил бүрийн эцэст стратеги төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг үндэслэн стратегийн төлөвлөгөөний тооцоолсон үр дүнг бодит үр дүнтэй харьцуулах, гүйцэтгэх ёстой ажил үйлчилгээ төлөвлөсөн цагтаа, төсөвлөсөн хүрээнд биелсэн эсэх, гадаад, дотоод орчны хүчин зүйлийн нөлөөллөөс болж өөрчлөлт орсон эсэх зэргийг нягталж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, тодотгол хийх саналыг Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгээс боловсруулж, Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж шийдвэрлүүлнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
2018 ОН

## ХАВСРАЛТ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭМЖҮҮР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЗОРИЛГО 1: ДАНГААР НОЁРХОЛГУЙ /ОЛОН ОРОЛЦОГЧТОЙ/, ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ, ТЭГШ БОЛОМЖ БҮХИЙ ШУДАРГА, ЧӨЛӨӨТ ӨРСӨЛДӨӨНТ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ.									
Стратегийн зорилт	Дэд зорилт	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Хариуцах газар, хэлтэс, албад	2018	2019	2020	2021	хэмжигдэхүйц	гөдөрхой
								Гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
Стратегийн зорилт 1.1. Зах зээлд нэвтрэх саад барихээнийг бууруулж, оролцогчдыг тэгш боломжоор хангах	1.1.1. Санхүүгийн салбарт өрсөлдөөнийг дэмжсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;	1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох судалгааг боловсруулж, хэлэлцүүлэх, батлуулах	Бүх нэгжүүд	100%	100%	100%	100%	Зохицуулалт, хяналт олон улсын стандартад чиглэгдэж, банкнаас бусад санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, цар хүрээ өргөжиж, бизнес эрхлэх ил тод, таатай орчин бүрдэж, хөрөнгө оруулалт нэмэгдэх боломж бүрдэж, банкнаас бусад санхүүгийн зах зээлийн санхүүгийн салбарт эзлэх хувь 15 хувиар нэмэгдсэн байна.	Хуулийн төсөл, холбогдох судалгааг боловсруулах зах зээлд оролцогч нараар хэлэлцүүлж саналыг авсан хуулийн төслийг Сангийн яаманд хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар дэмжүүлж, УИХ-д хүргүүлсэн, эсхүл УИХ-ын гишүүд өргөн бариулах арга хэмжээ авсан байх
		2. "Даатгалын тухай, "Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай" хуульд нэмэлт өөрчлөлтийн оруулах хуулийн төсөл, холбогдох судалгааг боловсруулж, хэлэлцүүлэх, батлуулах	ДГ, ХЭЗХ	100%	100%	100%	100%		
		3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох судалгааг боловсруулж, хэлэлцүүлэх, батлуулах	ББСБГ, ХЭЗХ	100%	100%	100%	100%		
		4. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох судалгааг боловсруулж, хэлэлцүүлж, батлуулах	ХЗХГ, ХЭЗХ	100%	100%	100%	100%		
		5. Үнэт цаасны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, холбогдох судалгааг боловсруулж, хэлэлцүүлэх, батлуулах	ҮЦГ, ХЭЗХ	50%	100%	100%	100%		
		6. Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, холбогдох судалгааг боловсруулж, хэлэлцүүлэх, батлуулах	ҮЦГ, ББСБГ, ДГ ХЭЗХ	50%	100%	100%	100%		
		7. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, холбогдох судалгааг боловсруулж, хэлэлцүүлэх, батлуулах	ҮЦГ, ХЭЗХ	50%	100%	100%	100%		
	1.1.2. Зах зээлд оролцогчдод тавигдах ноцол, шаардлагыг үйл ажиллагааны онцлогтой уялдуулан оновчтой тогтоох, хөнгөвчлөх	1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, бүртгэлийн тоог бууруулж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох, бүртгэх үйл ажиллагааг хялбаршуулах эрх зүйн орчин бүрдүүлэх	ҮЦГ, ББСБГ, ХЗХГ, ДГ ХЭЗХ	25%	50%	75%	100%	Банкнаас бусад санхүүгийн зах зээлд оролцогчдын таатай орчин бүрдэж, тусгай зөвшөөрлийн тоо 20 хувиар буурч, үйл ажиллагаа, үйлчилгээний нэр төрөл 30 хувиар дахин нэмэгдсэн байна.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх, бүртгэлийн тоог бууруулах, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох бүртгэх харилцааг бизнес эрхлэгч нарт ил тод нээлттэй, шат дамжлаг багатай, хялбар байхаар хуулийн төсөлд тусгаж, эрх зүйн орчинг бүрдүүлэх
	2. Зохицуулалтын байгууллагуудын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны төрөл, үйлчилгээний онцлог, олон улсын стандартад уялдуулан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, шаардлага, шалгуур үзүүлэлтийг оновчтой тогтоох	ҮЦГ, ББСБГ, ХЗХГ, ДГ СШЭХ	25%	75%	100%	100%	Зохицуулалтын байгууллагуудын өрсөлдөх чадвар/актив хөрөнгө, үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл / 50 хувиар нэмэгдэж, үйл ажиллагааны эрсдэл 30 хувиар буурсан байна.	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоосон байх	

	замаар тэдгээрийг дэмжих;	3. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох хүсэлтийг цахимжуулна.	ЗУГ, ҮЦГ, ББСБГ, ХЗХГ, ДГ	75%	100%	100%	100%	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох хүсэлтийг шийдвэрлэх хугацаа 40 хувиар буурсан байна.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох хүсэлтийг бүртгэх программ хангамжтай болсон байх.
Стратегийн зорилт 1.2. Санхүүгийн зах зээлд оролцогчдын мэдээллийн үнэн зөв, ил тод, нээлттэй байдлыг хангуулах замаар санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх.	1.2.1. Зах зээлд оролцогчдын бизнесийн хариуцлагыг сайжруулах замаар ил тод нээлттэй байдлыг хангуулах;	1. Мэдээллийн ил тод байдлыг хангах замаар хувьцаа эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг барагдуулах механизмыг олон улсын стандартад хүргэх	ХЗХГ	20%	40%	60%	100%	Зохицуулалтын байгууллагуудын харилцагчдаас прж буй өргөдөл, гомдлын тоо 40 хувиар буурсан байна.	Хувьцаа эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, гомдлыг барагдуулах тогтолцоо бүрдсэн байх
		2. Зохицуулалтын байгууллагууд үйлчлүүлэгчдээ үнэн зөв мэдээлэл, тайлагналаар хангах хариуцлагыг сайжруулж, ил тод байдлыг хангуулна.	ХШЗГ, ҮЦГ, ББСБГ, ХЗХГ, ДГ	25%	50%	75%	100%	Банкнаас бусад санхүүгийн зах зээлд оролцогчдын итгэл сайжирч, харилцагчдын тоо 50 хувиар нэмэгдсэн байна.	Үйлчлүүлэгчдээ үнэн зөв мэдээлэл, тайлагналаар хангах стандарт, хариуцлагын тогтолцоо бий болсон байх
		3. Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал, үйл ажиллагаанд мөрдөгдөх стандарт, хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	ҮЦГ	25%	50%	75%	100%		
		4. Үнэт цаасны арилжааны хяналтыг сайжруулах, үр дүнтэй цахим хяналтын тогтолцоог бүрдүүлэх буюу хөрөнгийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.		25%	50%	75%	100%		
		5. Компанийн засаглал, мэдээллийн ил тод байдлыг хангаж, хөрөнгө оруулагч харилцагчдын эрх ашгийг хамгаалах болон хариуцлагын тогтолцоог тус тус бий болгоно.	ХШЗГ	25%	50%	75%	100%	Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн тоо 40 хувиар нэмэгдсэн, харилцагч, үйлчлүүлэгчид учирч буй эрсдэл 40 хувиар буурсан байна.	Салбарын хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах болон хариуцлагын тогтолцоог бий болгосон байх
	Дэд зорилт 1.2.2. Санхүүгийн зах зээлийн харилцагчдад үнэн зөв мэдээллээр хангахад чиглэсэн ёс зүйн хэм хэмжээ төлөвшүүлэх;	1. Зохицуулалтын байгууллагын ажилтнуудад үйл ажиллагааны болон үйлчилгээний талаар харилцагч, үйлчлүүлэгчид үнэн зөв мэдээлэл өгч байх ёс зүйд сургах сургалтыг зохион байгуулна.	ББСБГ	25%	50%	75%	100%		Сургалт зохион байгуулсан байх
		2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн журмыг шинэчлэн боловсруулж, даатгалын зах зээлийн оролцогчдод зориулсан сургалтын хөтөлбөрт ёс зүй, хэм хэмжээ төлөвшүүлэх сэдвийг оруулах	ДГ	25%	50%	75%	100%	Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн ёс зүйн журмыг шинэчлэн боловсруулсан байна.	
		3. Зохицуулалтын байгууллагуудын ажилтнуудын хариуцлага, сахилга бат, ёс зүйг дээшлүүлэх талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ДГ, ББСБГ, ҮЦГ, ХЗХГ	25%	50%	75%	100%	Зохицуулалтын байгууллагад гарч буй зорчил 50 хувиар буурсан байна.	Зохицуулалтын байгууллагуудын ажилтнуудын хариуцлага, сахилга бат, ёс зүйг дээшлүүлэх талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байх

**ЗОРИЛГО 2: ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШИГ ХАМГААЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ**

Стратегийн зорилт	Дэд зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах газар, хэлтэс, албад	2018	2019	2020	2021	Тодорхой	Хэмжигдэхүйц	
								Хүрэх үр дүн	Хэмжих нэгж	
Стратегийн зорилт 2.1: Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх.	2.1.1 Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулах	1. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хяналт, зохицуулалтын дүрэм, журмыг боловсронгуй болгоно	Бүх нэгжүүд	50%	70%	100%	100%	Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хяналт, зохицуулалтын дүрэм, журмыг боловсруулсан байна. Хөрөнгө оруулагчдын санхүүгийн зах зээлд итгэх итгэл 40%-аар нэмэгдсэн байна.	Хөрөнгө оруулагчдын санхүүгийн зах зээлд итгэх итгэл /хувиар илэрхийлэх/	
		2. Хөрөнгө оруулагчийг хамгаалах сангийн эрх зүйн орчинг бий болгоно	ҮЦГ	25%	50%	75%	100%			
		3. Хялбарчилсан журмаар маргаан шийдвэрлэх зорилгоор санхүүгийн омбудсмен байгуулах асуудлыг судлана.	ДГ	15%	50%	100%	100%			
		4. Санхүүгийн зах зээлийг бүхэлд нь хамарсан санхүүгийн маргаан шийдвэрлэх механизмыг бий болгоно.	Бүх нэгжүүд	25%	50%	75%	100%			
		5. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах нэгжийн үйл ажиллагааг чадавхжуулна.	ХНПЗГ	25%	50%	75%	100%			
		6. Давхар барьцаалбартай холбоотой төрийн байгууллагуудын нэгдсэн зохицуулалтыг бий болгоно.	ББСБГ, ХЗХГ	25%	50%	75%	100%			
		7. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлагыг нутагшуулах.		20%	60%	80%	100%			
	2.1.2. Харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	1. Харилцагчийн хувийн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын хяналт, зохицуулалтын дүрэм, журмыг боловсронгуй болгох	Бүх нэгжүүд	50%	75%	90%	100%	Харилцагчийн хувийн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын хяналт, зохицуулалтын дүрэм, журмыг боловсруулсан байна. Харилцагчийн санхүүгийн зах зээлд итгэх итгэл 40%-аар нэмэгдсэн байна. Боловсон хүчинг бэлтгэсэн байна.	Харилцагчийн санхүүгийн зах зээлд итгэх итгэл /хувиар илэрхийлэх/	
		2. Холбогдох хуулийн шинэчилсэн найруулгад харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг тусгах	Бүх нэгжүүд	25%	50%	75%	100%			
		3. Санхүүгийн байгууллагын ажилтнуудыг харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр мэргэшүүлэх	Бүх нэгжүүд	20%	60%	80%	100%			
		4. Даатгалын тухай хууль тогтоомжийн шинэчилсэн найруулгад мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах талаар нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах	ДГ	25%	80%	100%	100%			
